

БАТЛАВ
СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗРЫН ДАРГА

..... Б.БИЛГҮҮН

БАТЛАВ
АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА

..... С.ЭНХБААТАР

СТАНДАРТ ХЭВЛЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2021 оны 12 дугаар сарын 06

Дугаар АТГ-2021/20

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Нэг талаас Стандарт, хэмжил зүйн газар, Улсын бүртгэлийн 9070002082, Регистрийн 9096035 дугаартай, түүнийг төлөөлж Стандартын мэдээлэл, лавлагаа, сургалтын төвийн дарга Ч.Содном (цаашид “гүйцэтгэгч” гэх), нөгөө талаас Улсын бүртгэлийн 9070002132., Регистрийн 9087389 дугаартай, Архивын ерөнхий газрыг төлөөлж Б.Цыгсүрэн /албан тушаал, нэр/ (цаашид “захиалагч” гэх) нар Иргэний хуулийн холбогдох заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 30.4 болон бусад хууль тогтоомжийн дагуу стандартын эмхэтгэл хэвлэн нийлүүлэхтэй холбогдсон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

1.2 Энэхүү гэрээний хавсралтууд, нэмэлт, өөрчлөлт, бүтээгдэхүүн хүлээлцсэн акт болон төлбөр төлсөн баримт зэрэг нь гэрээний салшгүй хэсэг байна.

Хоёр. Гэрээний үндсэн нөхцөл, хугацаа

2.1 Гүйцэтгэгч нь Захиалагчийн албан хэрэгцээ, даалгаврын дагуу гэрээний хавсралтад заасан нийт 3 стандартын жагсаалтад шүүлт хийж, хүчин төгөлдөр мөрдөж буй стандартыг захиалагчид хүссэн хэмжээ, тоогоор хэвлэн өгнө.

2.2 Стандарт, эмхэтгэлийн хэвлэлтэд тавигдах шаардлага. Үүнд:

Стандарт, эмхэтгэлийг хэвлэх хэмжээ: А4

Цаасны чанар: 70 г болон түүнээс дээш

Бусад шаардлага: “MNS 5553-1:2005, Хэвлэмэл бүтээгдэхүүнд тавих ерөнхий шаардлага. 1-р хэсэг: Ном, товхимол” стандартын шаардлагад нийцсэн байх

2.3 Гэрээний хугацаа нь 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдөр байна.

Гурав. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

3.1 Төлбөр төлөх хугацаа: Гэрээ байгуулснаас хойш 7 хоногийн дотор.

3.2 Энэхүү гэрээний нийт үнийн дүн 6,000,000.0 (зургаан сая) төгрөг байна (үүнд гэрээний дагуу туслан гүйцэтгэгчид төлбөл зохих гэрээт ажлын үнэ орсон).

3.3 Захиалагч нь Гүйцэтгэгчид төлбөл зохих гэрээний үнийн дүн 6,000,000.0 (зургаан сая) төгрөгөөс Гүйцэтгэгчийн Төрийн сан банкны 100900009012 тоот дансанд 4,350,000.0 (дөрвөн сая гурван зуун тавин мянга) төгрөгийг, Туслан гүйцэтгэгчид төлбөл зохих 1,650,000.0 (нэг сая зургаан зуун тавин мянга) төгрөгийг “Энзо принт” ХХК-ийн (Регистрийн дугаар 6257119), Голомт банк дахь 1415116938 дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг


4.1 Гэрээ хүчин төгөлдөр болсны дараа Захиалагчид төлбөрийн нэхэмжлэхийг хүргүүлнэ.

4.2 Гэрээнд заасан стандартын хувилан олшруулах эрхийг хамгаалах тухай тайлбар бичвэрийг стандарт нэг бүрд хийнэ.

4.3 Гэрээт ажлын тодорхой хэсгийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болно.

4.4 Гэрээт ажлын төлбөр бүрэн төлөгдсөнөөс хойш ажлын 10 хоногийн дотор хавсралтад дурдсан стандартыг Захиалагчид хэвлэмлээр хүлээлгэн өгнө.

4.5 Гэрээний хугацаанд стандартад өөрчлөлт орсон, хүчингүй болсон тохиолдолд Захиалагчид бичгээр мэдэгдэнэ.



4.6 Гэрээнд дурдсан стандартын хүчин төгөлдөр байдлыг хариуцна.

Тав. Захиалагчийн эрх, хүлээх үүрэг

5.1 Стандарт худалдан авах, стандартын эмхэтгэл хэвлүүлэх хүсэлтээ тоо, хэмжээг тодорхой зааж гүйцэтгэгчид албан бичгээр ирүүлнэ. Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, төлбөрийн нэхэмжлэлийн дагуу Гүйцэтгэгчид төлөх төлбөрийг СХЗГ-ын Төв төрийн сан банк дахь 100900009012 тоот дансанд шилжүүлнэ.

5.2 Худалдан авахаар гэрээгээр тохиролцсон Стандартын хэвлэлийн эхэд өөрчлөлт оруулахыг хатуу хориглоно. Стандартын эхэд нэмэлт болон өөрчлөлт орсноос үүсэх үр дагаврыг Захиалагч тал бүрэн хариуцна.

5.3 Гэрээний дагуу хүлээн авсан стандартын хувилах олшруулах эрхийг хамгаалах үүрэг хүлээж, хүлээн авсан стандартын эхийг зөвхөн гэрээнд заасан зорилгоор ашиглана.

5.4 Худалдан авсан стандартыг хэвлэн олшруулах, түгээх, бусдад дамжуулахыг хориглоно.

Зургаа. Авлигын эсрэг заалт

6.1 Талууд энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр шагнал, шан харамж, урамшуулал зэрэг гэрээнд тусгагдаагүй аливаа төлбөрийг харилцан төлөхгүй болно.

6.2 Захиалагч, түүний ажилтан нь энэхүү гэрээнд заасан ажил үүргийг гүйцэтгүүлэхдээ гүйцэтгэгчээс бэлэг, шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал авахыг хориглоно. Хэрэв захиалагч, түүний ажилтан бэлэг, шан харамжийн зүйл болон хууль бус хангамж, урамшуулал өгөхийг шаардсан тохиолдолд үүнийг Захиалагч талын эрх бүхий албан тушаалтан Д.Ганчимэгт Ganchimeg.d@archives.gov.mn хаягаар гүйцэтгэгч мэдээлэх үүрэгтэй.

Долоо. Бусад


7.1 Гэрээний үүргийн биелэлттэй холбогдон үүссэн маргаантай асуудлыг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Хэрэв талууд зөвшилцөлд хүрч чадахгүй бол асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

7.2 Энэхүү баримт бичгийг хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд уг хоёр хувь нэгэн адил хүчин төгөлдөр байна.

Гэрээ байгуулсан талуудыг төлөөлж:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

СХЗГ-ын Стандартын мэдээлэл, лавлагаа, сургалтын төвийн дарга

 Ч.Содном
СХЗГ-ын Санхүүгийн хэлтсийн дарга

 О.Оюунтуяа
Захиргаа, удирдлагын газрын Эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

 Б. Эрхүү


Туслан гүйцэтгэгч "Энзо принт" ХХК-ийн захирал

Нягтлан бодогч





Захиалагчийг төлөөлж:

АЕГ-ын Мэргэжил, арга зүйн удирдлагын газрын дарга

 Б.Цэндсүрэн
АЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга


 Х.Цогтбаатар
Захиргаа, удирдлагын газрын Эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

 Д.Ганчимэг



Хаяг: ХУД, 21 дүгээр хороо, Архивын ерөнхий газрын байр
Утас: 77002096, 77002054


Хаяг: БЗД, 4-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-46





БАРИМТ БИЧИГ MNS 5140:2021 ЭМХЭТГЭЛД ОРОХ СТАНДАРТЫН ЖАГСААЛТ

№	Стандартын эмхэтгэл, товхимолд орох стандартын нэр	Стандартын тэмдэглэгээ	Хэвлэх тоо
1	Баримт бичиг. 1-р хэсэг: Баримт бичгийн нэр, төрөл, тодорхойлолт	MNS 5140-1 :2021	500
2	Баримт бичиг. 2-р хэсэг: Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага	MNS 5140-2 :2021	
3	Баримт бичиг. 3-р хэсэг: Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлийг байрлуулахад тавих шаардлага	MNS 5140-3: 2021	
	НИЙТ: 6.000,000.00 төг (6.000,000.00)	42 х. Нэг бүрийн үнэ 12,000.00 төг	500 %



АТГ-2021/20 дугаартай гэрээний
03 дүгээр хавсралт



№	Эмхэтгэлийн нэрс	Үзүүлэлт	Хэмжээ	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Баримт бичгийн стандартын эмхэтгэл	Цаасны чанар: 70 г Хавтасны чанар: өнгө хөх, 250г, бүрэлттэй	A4, 44+ нүүр	500	12,000	6,000,000.0
	Нийт үнэ, төгрөг			500		6,000,000,0
	Үүнд: Гүйцэтгэгчид шилжүүлэх			500		4,350,000,0
	Туслан гүйцэтгэгчид шилжүүлэх			500		1,650,000,0

